

# МОСТ ФИНТЕК ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо  
Сэнтрал Тауэр 13-р давхар, 1313 тоот



Утас: 75052727  
Мэйл хаяг: info@most.mn

## МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 16-ны өдөр

№ ХЭХ #3/24

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг шинээр сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1, 2024 оны 02 сарын 16-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураасан дүн, Тооллогын комиссын 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 2/24 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхийн санал авсан дараах нэр дэвшигчдийг ТУЗ-ийн “Ердийн” гишүүдээр сонгон ажиллуулсугай. Үүнд:
  - Авирын Сүхдорж;
  - Баасандоржийн Мөнхцэцэг;
  - Сүхдоржийн Оргил;
  - Чулууны Ганхуяг;
  - Гэрэлтийн Тэлмэн;
  - Чойжамцын Чинбат.
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхийн санал авсан дараах нэр дэвшигчдийг ТУЗ-ийн “Хараат бус” гишүүдээр сонгон ажиллуулсугай. Үүнд:
  - Баатарын Оюунжаргал;
  - Ганбаатарын Тэлмэн;
  - Сангидаасүрэнгийн Сүхболд.
- Энэ тогтоол гарсантай холбогдуулан компанийн өмнөх ТУЗ-ийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д даалгасугай.
- Энэхүү тогтоолын 3 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа бүрэн эрхийг тус компанийн хуулийн зөвлөх /М.Номинчулуу/-д итгэмжилсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



А.СҮХДОРЖ



**МОСТ ФИНТЕК ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо  
Сэнтрал Тауэр 13-р давхар, 1313 тоот



**Утас:** 75052727  
**Мэйл хаяг:** info@most.mn

**МОСТ ФИНТЕК ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 02-р сарын 16-ны өдөр

№ ХЭХ #2/24

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, дэх хэсэг, 2024 оны 02 сарын 16-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураасан дүн, Тооллогын комиссын 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 2/24 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хэлбэр өөрчлөгдөж буйтай холбогдуулан дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт зааснаар компанийн дүрмийг шинэчлэн баталсантай холбогдуулан “МОСТ Финтек” ХХК-ийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилсүгэй.
3. Компанийн дүрмийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын 3 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа бүрэн эрхийг тус компанийн хуулийн зөвлөх /М.Номинчулуу/-д итгэмжилсүгэй.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА**



**А.СҮХДОРЖ**

## МОСТ ФИНТЕК ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо  
Сэнтрал Тауэр 13-р давхар, 1313 тоот



Утас: 75052727

Мэйл хаяг: info@most.mn

### МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 16-ны өдөр

№ ХЭХ #1/24

Улаанбаатар хот

Компанийн хаягийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 болон 10.5 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15, 2024 оны 02 сарын 16-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураасан дүн, Тооллогын комиссын 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 2/24 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их сургуулийн гудамж, Сүхбаатарын талбай 2, Цэнтрал Тауэр 17 давхарт хэмээн өөрчилсүгэй.
2. Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Оргил/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа бүрэн эрхийг тус компанийн хуулийн зөвлөх /М.Номинчулуу/-д итгэмжилсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

